

ЭРХЗҮЙН АСУУДАЛ

ХУУЛЬ САХИУЛАХ САЛБАРЫН ЖЕНДЕРИЙН ЭРХ ТЭГШ
БАЙДЛЫГ ХАНГАХ ЗАРИМ АСУУДАЛ**Б.Анун**

Дотоод хэргийн их сургуулийн Удирдлагын академийн 7081 дүгээр дамжааны суралцагч, дэслэгч

Товч агуулга: Монгол улс дахь жендерийн тэгш байдал ялангуяа хууль сахиулах байгууллагын жендерийн тэгш байдлын өнөөгийн нөхцөл байдлыг судлах, нөлөөлж буй хүчин зүйлүүдийг тодорхойлж эмэгтэйчүүдийн оролцоог нэмэгдүүлэх шаардлага үүсэж байна. Эмэгтэйчүүд уян зөөлөн, энэрэнгүй зан чанар, байгалиасаа бусдыг хайрлах, бусдын төлөө өөрийгөө зориулдаг өмгөөлөгч, багш, эмч гэх мэт мэргэжлүүдийг их сонгож ар гэр, гэр бүлийн амьдралдаа үүрэг роль ихтэй оролцсоор хууль хүчний байгууллагуудаас зайгаа авч байна. Хууль сахиулах байгууллагад жендерийн тэгш байдлыг хангахад улс төр, эдийн засаг, нийгэм, соёлын хүрээн дэх арга хэмжээ, үйл ажиллагаанууд чухал нөлөө үзүүлдэг.

Summary: There is a need to study the current situation of gender equality in Mongolia, especially the gender equality of law enforcement agencies, and to identify the influencing factors and increase the participation of women. Because of their flexible and compassionate nature, love for others, and dedication to others, women often choose professions such as lawyers, teachers, doctors, etc. Actions in the political, economic, social, and cultural spheres have an important impact on achieving gender equality in law enforcement

Түлхүүр үгс: Жендер, Хууль сахиулах байгууллага, Жендерийн тэгш байдал, Улс төр, Нийгэм соёл, Төрийн тусгай алба хаагч, Эмэгтэйчүүдийн оролцоо, Чадвар, Жам ёсны эрх

Keywords: Gender, Law Enforcement, Gender Equality, Politics, Socio-Culture, Special Civil Service, Women's Participation, Competence, Human Rights

Жендер гэж юу вэ? Дэлхийн түүхэнд 1950 он хүртэл хүйс ба жендерийг нэг ижил утгатайгаар ойлгодог байжээ. Жендерийн сургаалын үүсэл нь анх 20 дугаар зууны эхэн үеэс эмэгтэйчүүдийн эрх, эрх чөлөөг хамгаалахаар гарч ирсэн ойлголт байсан ба аажимдаа нийгэм, соёлын бүхий л салбарыг хамруулсан жендер судлал болтлоо хөгжсөн байна ¹ . Жендер гэж зөвхөн

¹ <https://medium.com/@awaremongolia/>

эрэгтэй эмэгтэй гэх хоёр хүйсийн тухай ойлголт биш. Жендерийн агуулга нь нийгэм, соёл бүрд харилцан адилгүй бөгөөд цаг хугацаанд хувиран өөрчлөгдөж байдгаараа биологийн шинжлэх ухаанаар тодорхойлогдсон хүйс хэмээх нэр томъёоноос ялгаатай.

Хууль сахиулах салбарын жендерийн эрх тэгш байдлыг хангах зарим асуудлын талаар судлахын өмнө хууль сахиулах байгууллага болон жендерийн эрх тэгш байдлын тухай ойлголтыг товч авч үзье.

Монгол улсад хууль сахиулах чиг үүргийг цагдаагийн ерөнхий газар, хил хамгаалах байгууллага, шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага, онцгой байдлын ерөнхий газар, шүүх шинжилгээний ерөнхий газар, төрийн тусгай хамгаалалтын газрууд хэрэгжүүлдэг. Хууль сахиулах гэж зөрчил шалгах болон нийтийн хэв журмыг хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах ажиллагааг хэлнэ.¹ Хууль сахиулах байгууллагууд нь энэхүү ажиллагааны явцад шуурхай, энэрэнгүй байх, нууцлалыг хамгаалах, хүний эрх, эрх чөлөөг дээдлэх, эрүү шүүлт, хүнлэг бус харьцаанаас ангид байх зарчмыг баримтална.

Хууль сахиулах салбарт жендерийн эрх тэгш байдал хэрхэн хангагдаж ямар бодлогыг баримталж байна вэ?

Жендерийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийн 10.1.3-т “Зэвсэгт

хүчин, хилийн ба дотоодын цэрэг, тагнуул, цагдаа, шүүхийн шийдвэр гүйцэтгэх, авлигатай тэмцэх болон онцгой байдлын байгууллагаас бусад байгууллагын төрийн тусгай албан тушаалтны дотор аль нэг хүйсийн төлөөлөл 40 хувиас доошгүй байх² гэж заасан байна. Төрийн тусгай алба нь үндэсний болон хүн амын аюулгүй байдлыг хангах, нийгмийн хэв журам болон хууль дээдлэх үндсэн зарчмыг сахиулахтай холбогдсон төрийн тусгай чиг үүргийг хэрэгжүүлдэг, биеийн болон сэтгэлзүйн байнгын бэлтгэл шаардсан, тушаалаар үүрэг гүйцэтгэдэг онцлогтой юм.³ Төрийн тусгай албан тушаалд Монгол Улсын Үндсэн хууль, бусад хуульд заасан журмын дагуу үндэсний болон хүн амын аюулгүй байдлыг хангах, нийгмийн хэв журам болон хууль дээдлэх үндсэн зарчмыг сахиулахтай холбогдсон төрийн тусгай чиг үүргийг хэрэгжүүлэх албан тушаал болох Үндсэн хуулийн цэцийн гишүүн, бүх шатны шүүхийн шүүгч, прокурор, Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн нарийн бичгийн дарга, Монгол банкны Ерөнхийлөгч, Тэргүүн дэд, дэд ерөнхийлөгч, Санхүүгийн зохицуулах хорооны дарга, орон тооны гишүүн, Үндэсний статистикийн хорооны дарга, дэд дарга, Сонгуулийн ерөнхий хорооны дарга, нарийн бичгийн дарга, Хүний эрхийн үндэсний комиссын дарга, гишүүн, Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх асуудал эрхэлсэн гишүүн, Шүүхийн ерөнхий зөвлөл

¹ <https://vip76.mn/content/40935>

² Жендерийн эрх тэгш байдлын тухай хууль 2011 он Төрийн мэдээлэл эмхэтгэл: №08

³ Хүний эрхийн үндэсний комисс 22 дах илтгэл

болон Шүүхийн сахилгын хорооны дарга, гишүүн, Үндэсний болон орон нутгийн аудитын газар, Авлигатай тэмцэх газрын удирдах, гүйцэтгэх албан тушаал, зэвсэгт хүчин, хилийн ба дотоодын цэрэг, онцгой байдал, тагнуул, төрийн тусгай хамгаалалт, гадаадын иргэн, харьяат, цагдаа, шүүхийн шийдвэр гүйцэтгэх, шүүх шинжилгээний, байгууллагын удирдлага, дипломат албан тушаал, зэвсэг хүчин, хилийн ба дотоодын цэрэг, онцгой байдал, тагнуул, төрийн тусгай хамгаалалт, гадаадын иргэн, харьяат, цагдаа, шүүхийн шийдвэр

гүйцэтгэх, шүүх шинжилгээний, байгууллагын офицер, ахлагч, шүүхийн шийдвэр гүйцэтгэгч, гаалийн байцаагч, шүүх шинжилгээний байгууллагын шинжээч, мэргэжилтэн, харьяатын байгууллагын ажилтан, хуульд заасан бусад албан тушаалыг¹ хамааруулдаг.

Төрийн тусгай албанд ажиллаж буй эмэгтэйчүүдийн эзлэх хувийг бусад төрийн захиргааны, улс төрийн, үйлчилгээний албанд ажиллаж буй эмэгтэйчүүдийн эзлэх хувьтай ² харьцуулбал:

Төрийн алба	Хэдээс хэдэн онд	Нийт алба хаагчдын тоо	Эмэгтэйчүүдийн хэмжээ (тоо)	Эмэгтэйчүүдийн хэмжээ (хувиар)
Төрийн тусгай алба	2021	45899	11981	26.1%
	2022	47158	13318	28.2%
	2023	47657	13049	27.38%
Төрийн улс төрийн алба	2021	4166	1013	24.3%
	2022	3959	892	22.5%
	2023	3898	901	23.1%
Төрийн захиргааны алба	2021	21135	13286	62.8%
	2022	22023	14408	65.4%
	2023	21639	14323	66.2%
Төрийн үйлчилгээний алба	2021	137665	104443	75.8%
	2022	152265	116936	76.7%
	2023	153302	115910	75.6%

Дээрх харьцуулалтаас харахад Төрийн тусгай алба болон төрийн улс төрийн албанд ажилладаг эмэгтэйчүүдийн эзлэх хувь бага байна. Төрийн тусгай албанд болон төрийн улс төрийн албанд ажиллаж буй эмэгтэй эрэгтэй хүмүүсийн тооны харьцаа 70:30 байгаа бол төрийн

захиргааны алба болон төрийн үйлчилгээний алба нь эсрэгээрээ 30:70-н харьцаатай байна. Зөвхөн эмэгтэйчүүдийн тоо эзлэх хувиас гадна төрийн тусгай албанд ажиллаж буй эмэгтэйчүүдийн жендерийн тэгш эрхийг боловсрол, эдийн засаг, эрүүл


¹ Төрийн албаны тухай хууль 2018 он *Төрийн мэдээлэл эмхэтгэл: №01*

² Төрийн албан хаагчийн улсын нэгдсэн тоо бүртгэлийн 2023 тайлан

мэнд, нийгэм соёлын хүрээнд хэрхэн хангаж байгаа тухай судалгаа авахад:



Судалгаанд оролцогчдын 54% буюу 215 эмэгтэй, 46% буюу 180 нь эрэгтэй алба хаагчид байна. Үүнээс аль аль байгууллагад ажилладаг вэ?



Цагдаа дотоодын цэргийн байгууллагаас эрэгтэй 43, эмэгтэй 59 нийт 102, Хил хамгаалах байгууллагад эрэгтэй 45, эмэгтэй 48, нийт 93, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагаас эрэгтэй 54, эмэгтэй 61 нийт 115, Онцгой байдлын байгууллагаас эрэгтэй 38, эмэгтэй 47 нийт 85 алба хаагчдад энэхүү

судалгаанд хамрагдсан байна. Судалгаанд оролцогчдоос Жендерийн эрх тэгш байдал гэж таны бодлоор ямар ойлголтыг хэлэх вэ? гэх нээлттэй асуулгыг асуухад дийлэнх хувь нь хүйсийн тэнцвэрт байдал, эрэгтэй эмэгтэй хүний хүйсийн тэнцүү байдал гэж хариулсан ба зарим судалгаанд оролцогчид эрэгтэй эмэгтэй хүмүүсийн

нийгмийн баталгаа, нийгэмд эзэлж буй байр суурь, бүхий л салбарт эрэгтэй эмэгтэй хүмүүс адил тэгш эрх эдлэх зарчим гэж хариулсан. Цөөн хэдэн хувь нь хүний эрхийн салшгүй ойлголт, байгууллагуудын ажилчдын дунд мөрдөгдөх шаардлагатай зүйл гэж хариулсан байна. Судалгаанд оролцогчдын ихэнх хувь нь нийгмийн олонхтой адил ойлголттой байгаа бөгөөд жендер бол зөвхөн эрэгтэй эмэгтэй хүмүүс хүйсийн хувьд тэнцүү байх гэж ойлгож байна. Жендерийн

тэгш байдлыг Жендерийн эрх тэгш байдлыг хангах тухай хуульд тодорхойлсон байх ба эрэгтэй эмэгтэй хүмүүсийг хүйсийн хувьд ялгаатай гэж биологийн талаас нь тодорхойлох төдий ойлголт бус харин тэднийг боловсрол, эрүүл мэнд, хөдөлмөр эрхлэлт, эрх чөлөө, эдийн засгийн баталгаа, зэрэг нийгэмд эзлэх байр суурь, манлайлал, мэдлэг, ур чадвар, хөдөлмөрийн нөхцөл байдал зэргийг тодорхойлох тухай өргөн ойлголт¹ юм.

3. Ажиллаж байх хугацаанд жендерийн эрх тэгш байдлыг хангахтай холбоотой төсөл, судалгааны ажил, аль эсхүл сургалтад хамрагдаж байсан уу?

- Монгол улсад хууль сахиулах ажиллагаанд хүний эрх, жендерийн эрх тэгш байдлыг дээшлүүлэх нь төсөл
- Эмэгтэйчүүдийн манлайллын хөтөлбөр
- Жендерийн эрх тэгш байдлыг хангах үндэсний хөтөлбөр
- Жендэрт суурилсан хүчирхийлэлтэй тэмцэх нь төсөл
- Би жендерийн хэвшмэл ойлголтын эсрэг байна.



Дээрх судалгаанаас харахад нийт байгууллагуудын судалгаанд хамрагдсан алба хаагчид Монгол улсад хууль сахиулах ажиллагаанд хүний эрх,

жендерийн тэгш байдлыг дээшлүүлэх нь төсөл, Эмэгтэйчүүдийн манлайллын хөтөлбөр болон Жендерийн эрх тэгш байдлыг хангах үндэсний хөтөлбөрт

¹ А.Гантуул. Шийдвэр гаргах түвшин дэх жендерийн тэгш байдлыг хангах зарим асуудал,

Хууль сахиулахуйн удирдлага сэтгүүл №03, 2021 он

ойролцоо тооны хамрагдаж байсан бол Цагдаа, дотоодын цэргийн байгууллага, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын судалгаанд оролцогчид Жендерт суурилсан хүчирхийлэлтэй тэмцэх төсөлд ижил хамрагдсан байна. Мөн шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын судалгаанд оролцогчид л зөвхөн Би жендерийн хэвшмэл ойлголтын эсрэг байна гэх сургалтын нэршлийг шинээр нэрлэсэн байна. Энэ нь аль нэг төслийн хүрээнд зохион байгуулсан арга хэмжээ байж болох юм. Харин нийт байгууллагуудын судалгаанд оролцогчдын 30% нь буюу 112 нь ажиллаж байх хугацаандаа жендерийн эрх тэгш байдлыг хангахтай холбоотой төсөл, судалгаа, сургаалтанд хамрагдаж байгаагүй гэжээ. Монгол улсад ялангуяа хууль сахиулах байгууллагуудын алба хаагчид Монгол улсад хууль сахиулах ажиллагаанд хүний эрх жендерийн тэгш байдлыг дээшлүүлэх нь төсөлд ямар нэгэн арга хэмжээ, үйл ажиллагаагаар дамжуулан хамрагдсан байх нь зүйтэй. Тэгэхээр нийт хууль сахиулах байгууллагууд болон ажиллаж буй алба хаагчид төслийн хүрээнд арга хэмжээ зохиож байж жендерийн тэгш байдлыг хангахад эерэг нөлөө үзүүлнэ. Гэхдээ зөвхөн хууль, дүрэм журмыг дагаж мөрдөж төсөл, сургалт судалгаа явуулснаар хууль сахиулах байгууллагад жендерийн тэгш байдал хангагдахгүй. Жендерийн тэгш байдлыг хангахын тулд улс төр, эдийн засаг, хөдөлмөрийн харилцаа, соёл

боловсрол, эрүүл мэнд, гэр бүлийн харилцаа гэх мэт олон хүчин зүйлд нөлөөлөн тодорхой зарчмын хүрээнд бодлого баримтална.

Нэгдүгээрт. Улс төрийн хүрээнд дэх жендерийн эрх тэгш байдлын баталгаа- Улс төрийн нам, үйлдвэрчний эвлэлийн болон олон нийтийн байгууллагад гишүүнээр эвлэлдэн нэгдэх, тэдгээрийн үйл ажиллагаанд оролцох эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн тэгш эрх, тэгш боломжийг хязгаарлах, ялгаварлан гадуурхахыг хориглодог.¹

Хууль сахиулах байгууллагын ажилтан нь сонгох, сонгогдох эрхээ эдлэх ба шууд сонгох эрхээ эдэлж нэр дэвшигчийн талаар саналаа нууцаар гаргана. Мөн хууль сахиулах байгууллагууд Хууль зүйн яамны харьяа үйл ажиллагаагаа явуулна. Хууль зүйн яам төрийн бодлогууд Алсын хараа-2050 Монгол улсын урт хугацааны хөгжлийн бодлого, Монгол улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030 гэх мэт бодлогуудын хүрээнд төлөвлөгдсөн төсөл, үндэсний хөтөлбөрүүд үйл ажиллагаануудыг явуулсаар байгаа бөгөөд Хууль сахиулах салбар дах хамгийн том жишээ нь Хууль сахиулах байгууллагуудын жендерийн нэгдсэн бодлого (2018-2021) юм. Энэхүү бодлогын хэрэгжилтийг хууль сахиулах байгууллагууд хээржүүлэн ажиллах үүрэгтэй.

Хоёрдугаарт. Эдийн засгийн хүрээнд дэх жендерийн эрх тэгш


¹ Монгол улсын жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээ 2022 он

байдлын баталгаа- Эдийн засгийн үйл явц нь хүн ба нийгмийн хязгаарлагдсан нөөц, хүний хязгааргүй хэрэгцээний зөрчилдөөнтэй нөхцөлд нарийн төвөгтэй, бүх зүйлийг хамарсан цогц тогтолцоо юм. Эдийн засгийн хүрээ нь маш өргөн ойлголт ба хууль сахиулах байгууллагуудын алба хаагч нэг бүрийг авч үзвэл тэдгээрийн санхүүгийн байдалтай шууд холбоотой. Алба хаагчдын санхүүгийн эх үүсвэр нь цалин хөлс байдаг.

Судалгаанд хамрагдсан алба хаагчдаас “Алба хаагчдын дунд зөвхөн

хүйсээс шалтгаалан цалин, урамшуулал, хангамжийн зөрүү гардаг уу? ” гэсэн асуултад судалгаанд оролцсон алба хаагчдын 93% буюу 378 алба хаагч Үгүй 7% буюу 27 алба хаагч тийм гэж хариулсан байна. Энэ ойлголт 100% Үгүй байх ёстой ба цалин хөлсийг тухайн алба хаагчийн албан тушаал, ажилласан жил, боловсролын зэрэг, гүйцэтгэлийн тайлан, уралдаанд тэмцээнд оролцож байгууллага, албаны болон улсынхаа нэрийг гаргаж амжилт үзүүлсэн бол урамшуулал олгож цалин хөлсийг дүрэм, журамд заасны дагуу нэмэгдүүлнэ.

Та сард хэдэн төгрөгийн цалин авдаг вэ?



Нийт судалгаанд оролцогчдоос 4000000-с дээш цалин авдаг алба хаагч байхгүй. 52% буюу 211 алба хаагч 2000000-3000000 төгрөгийн цалин авч байна. Техник технологи асар Хурдтай хөгжиж инфляц ихсэн өдрөөс өдөрт үнийн хөөрөгдөлд автаж буй 21-р зуунд зөвхөн үндсэн цалингаараа амьдарч хүрэлцэх үү гэж нийт судалгаанд оролцогчдоос асуухад 86% нь хүрэлцдэггүй цалингаас нэмүүлэх шаардлага байдаг. Цалин нэмлээ ч багаар нэмдэг. гэж хариулжээ.

Цалин хөлстэй холбоотойгоор Цагдаагийн байгууллагын ажилтан Б.С-тэй ярилцахад:

Та хэдэн төгрөгийн цалин авч байна вэ? Таны амьдралд хүрэлцдэг үү? гэж асуухад:

Би Одоогоор гар дээр 2.280.000-с 2.360.000 төгрөг авдаг. Энэ цалингаар зөвхөн өөрийн хэрэгцээгээ болгож амьдарна гэвэл болгоод амьдарч чадна аа. Амьдралаа болгоно гэвэл их хэцүү. Би одоо 3 хүүхэдтэй бүгд ерөнхий боловсролын сургуульд суралцдаг. Сургуульд суралцахад хувцас,

хичээлийн хэрэгслээс гадна, өдөр тутмын хоол хүнс гээд үндсэн цалин хүрэлцдэггүй. Бүр нөхөр бас ажилладаг хоёулаа цалинтай тулдаа л болгодог. Цалин нэм гэж шаардахгүй нэг үеэ бодвол нэлээн сайжирсан. Харин Эмэгтэйчүүд биднийг төр засан харж хандах хэрэгтэй байна. Бидний жам ёсны үүрэг бол үр хүүхдээ төрүүлэх. Хүүхэд төрүүлээд үндсэн ажлаа хийж чадахгүй учраас цалин авдаггүй харин хүүхдийн тэтгэмж, болон жирэмсэн болог амаржсаны тэтгэмжийг нэмэгдүүлэх хэрэгтэй байна гэв. Нэг талаасаа энэ нь эмэгтэй хүний онцлогт тохируулан тэтгэмж өгч байгаа зүй ёсны хэрэг ч гэлээ нэмэгдүүлэх шаардлагатай гэдгийг олон ээжүүдийн нэгэн төлөөлөл энэхүү ярилцлагад дурдсан юм. Төрийн алба хаагчийн цалингийн хувьд хүйсээр ялгаварлахгүйгээр тусгай шаардлагын дагуу цалинжуулдаг ч өрх толгойлсон эх, эцэг нарыг судлан хүний эрхийн мэдрэмжтэй бодлогыг баримтлан цалин хөлс тэтгэмжийг нэмэгдүүлэх нь эрэгтэй эмэгтэй хүмүүсийн онцлогийг ялгаж салган тэгш эрхийг тогтоох жишээ болж болох юм.

Төрийн албан дахь жендерийн эрх тэгш байдлын баталгаа

"Төрийн алба" гэж төрийн зорилт, чиг үүргийг Монгол Улсын Үндсэн хууль, бусад хууль тогтоомжийн хүрээнд хэрэгжүүлэх, төрийн бодлого боловсруулах, төрөөс зайлшгүй үзүүлэх шаардлагатай бусад үйлчилгээг

нийтэд хүргэх үйл ажиллагаа, бүтэц, зохион байгуулалтыг;

"Төрийн албан хаагч" гэж төрийн албан тушаалыг эрхэлж, эрх, үүргээ хэрэгжүүлсний төлөө төрөөс цалин хөлс авч, ажиллах нөхцөл, баталгаагаар хангагдан ажиллаж байгаа этгээдийг хэлнэ. Төрийн тусгай алба хаагч, үйлчилгээний алба хаагчид төрийн албан тушаалыг хашиж байгаагийн хувьд жендерийн эрх тэгш байдлыг хангах бодлогыг баримтлах нь төрийн албаны байгууллагуудын үүрэг юм.

Төрөөс эрэгтэй, эмэгтэй хүний төрийн албанд орох, албан тушаал эрхлэх тэгш эрх бодитой хэрэгжих боломж, нөхцөлөөр хангахын тулд дараах бодлого хэрэгжүүлнэ:

- Томилогдох төрийн улс төрийн албан тушаалтны дотор аль нэг хүйсийн төлөөлөл Засгийн газар, аймаг, нийслэлд 15 хувиас, дүүрэгт 20 хувиас, суманд 25 хувиас, хороонд 30 хувиас доошгүй байх;

- Төрийн захиргааны удирдах албан тушаалтны дотор аль нэг хүйсийн төлөөлөл яамдын Төрийн нарийн бичгийн дарга, Засгийн газрын агентлагийн даргын 15 хувиас, бусад төв байгууллагын удирдлагын 20 хувиас, яамдын газар, хэлтсийн даргын 30 хувиас, аймаг, сум, нийслэл, дүүргийн Засаг даргын Тамгын газрын дарга, хэлтэс, албадын даргын 40 хувиас доошгүй байх;

- Зэвсэгт хүчин, хилийн ба дотоодын цэрэг, тагнуул, цагдаа, шүүхийн шийдвэр гүйцэтгэх, авлигатай тэмцэх болон онцгой

байдлын байгууллагаас бусад байгууллагын төрийн тусгай албан тушаалтны дотор аль нэг хүйсийн төлөөлөл 40 хувиас доошгүй байх;

- Төрийн үйлчилгээний удирдах албан тушаалтны дотор аль нэг хүйсийн төлөөлөл илт давамгайлсан тохиолдолд 40:60 гэсэн харьцааг хангах бодлого, арга хэмжээг тусгай хөтөлбөр, төлөвлөгөөний дагуу хэрэгжүүлэх бөгөөд энэ хуулийн 6.5.6-д заасан тохиолдолд энэ заалт үл хамаарна.

- Төрийн байгууллагын дэргэдэх болон үндэсний хэмжээний хороо, зөвлөл, комисс зэрэг зөвлөлдөх буюу хамтын удирдлагын байгууллагад аль нэгэн хүйсийн төлөөлөл нийт гишүүний 40 хувиас доошгүй байна.

- Төрийн ба төсөвт байгууллагын нийт ажилтны дунд аль нэг хүйсийн төлөөлөл илт давамгайлсан тохиолдолд хүйсийн 40:60 гэсэн харьцаа бүхий тэнцвэрт байдлыг хангах нөхцөлийг бүрдүүлэх бодлого, арга хэмжээг хүний нөөцийн төлөвлөгөөнд тусгаж хэрэгжүүлнэ.

Төрийн байгууллагуудаас хууль сахиулах салбар дах жендерийн эрх тэгш байдлыг тухайлан авч үзвэл. Монгол улсад хууль сахиулах чиг үүргийг цагдаагийн ерөнхий газар, хил хамгаалах байгууллага, шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага, онцгой байдлын ерөнхий газар, шүүх шинжилгээний ерөнхий газар, төрийн тусгай хамгаалалтын газрууд хэрэгжүүлдэг. Хууль сахиулах гэж

зөрчил шалгах болон нийтийн хэв журмыг хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах ажиллагааг хэлнэ. Хууль сахиулах байгууллагууд нь энэхүү ажиллагааны явцад шуурхай, энэрэнгүй байх, нууцлалыг хамгаалах, хүний эрх, эрх чөлөөг дээдлэх, эрүү шүүлт, хүнлэг бус харьцаанаас ангид байх зарчмыг баримтална. Жендерийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийн 10.1.3-т “Зэвсэгт хүчин, хилийн ба дотоодын цэрэг, тагнуул, цагдаа, шүүхийн шийдвэр гүйцэтгэх, авлигатай тэмцэх болон онцгой байдлын байгууллагаас бусад байгууллагын төрийн тусгай албан тушаалтны дотор аль нэг хүйсийн төлөөлөл 40 хувиас доошгүй байх гэж заасан байгаа нь хууль сахиулах байгууллагуудад жендерийн тэгш эрхийг хангах хүйсийн төлөөллийн тоог

нэмэгдүүлэхэд сөргөөр нөлөөлж байна. Дээрх хуулийн заалтын хүрээнд судалж харьцуулан дүгнэхэд төрийн тусгай алба болон төрийн улс төрийн албанд ажиллаж буй эмэгтэйчүүдийн тоо бага байсан. Учир хууль сахиулах байгууллагын боловсон хүчний онцлог эрэлхэг зоригтой, шийдэмгий, удирдагч, бие бялдрын хөгжил сайтай гэх мэт гол төлөв эрэгтэй хүнд байх мөн чанар чадварыг шаарддаг бол эмэгтэйчүүд уян зөөлөн, энэрэнгүй байдаг учраас эмч, багш гэх мэт боловсрол үйлчилгээний ажилтан болох сонирхолтой байдаг. Гэвч хууль сахиулах байгууллагад жендерийн

тэгш байдлыг хангаж
эмэгтэйчүүдийг оролцуулах
шаардлагууд байдаг.

Жишээ эмэгтэй хүний уян зөөлөн зан чанар, нарийн нандин мэдрэмж шаардсан хууль сахиулах байгууллага дах сэтгэл зүйч, нийгмийн ажилтан, хүний нөөц, ар тал, соёл олон нийт хариуцсан мэргэжилтэн зэрэг хэрэгцээ шаардлагатай албан тушаалууд бий. Эмэгтэйчүүд хууль сахиулах байгууллагад ажилласнаар шударга, ёс зүй сайтай, зохион байгуулалттай зөвхөн өөрийгөө бус бусдыг өмгөөлөн хамгаалж зөв төлөвшилд хүргэх давуу талтай. Хууль сахиулах салбарт эмэгтэй алба хаагчдын тоог зөвхөн нэмснээр жендерийн тэгш байдал хангагдахгүй. Эмэгтэйчүүдийн чадавхжигчаас их хамаарна, Хууль сахиулах салбарт чадвартай алба хаагч болох нь суралцахаас эхэлнэ. Хууль сахиулах байгууллагуудын боловсон хүчнийг бэлтгэдэг ганц бүрэн эрхтэй сургууль бол Монгол Улсын Дотоод хэргийн их сургууль юм. Дотоод хэргийн их сургуульд нийт элсэгчдийн 20-30 хувь нь эмэгтэй элсэгчид байдаг ба ойролцоогоор 2019 онд 60-70, 2020 онд 20-30, 2021 онд 40-50, 2022 онд 50-60 2023 онд 100-120, 2024 110-120 эмэгтэй элсэгчдийг элсүүлэн суралцуулж жилээс жилд нэмэгдэж байгаа нь Ирээдүйд хууль сахиулах салбарын жендерийн тэгш байдалд үнэтэй хөрөнгө оруулж байгаагийн тод жишээ юм. Тэгэхээр хууль сахиулах байгууллагад ажиллаж буй эмэгтэй алба хаагчдын тоог

нэмэгдүүлэхийн тулд
Эмэгтэйчүүдийн хүсэлт сонирхлыг татах хууль сахиулах байгууллагат ажиллах давуу талыг сурталчлахаас эхлээд хуулийн зүйл заалтад өөрчлөлт оруулах дүрэм журам тогтоох шаардлагатай юм.

Дүгнэлт

Хүний амьдралын бүхий л салбарт жендер эрх тэгш байдлыг хангах хэрэгцээ оршсоор байна. Төрийн албанд ч тэр төрийн бус байгууллага ч тэр гэр бүлийн харилцаанаас улс төрийн харилцаа хүртэл. Жендерийн эрх тэгш байдал хангагдсанаар шударга байдал нийгэмд тогтоож ялгаварлан гадуурхах үзлээс ангид байж аливаа үйл ажиллагаа илүү бүтээмж сайтай байх болно. Бүх хүн тэгш эрхтэй учраас хэн ч аль ч салбарт гадна төрх, хүйс, гарал үүсэл гэх мэт шалтгаанаар гадуурхагдаж үл болно. Жендер бол ялгаварлан гадуурхалтыг үл бий болгож эрэгтэй, эмэгтэй аль ч хүйсийн хүмүүст ижил тэгш боломж олгон бүхий л харилцаанд үүрэг, хүлээх хариуцлага, тэднийг нийгэмд эзлэх байр суурийн уламжлагдан тогтсон түүхэн явцад өөрчлөгддөг ойлголт үзэл хандлага юм.

Хууль сахиулах байгууллагад жендерийн эрх тэгш байдлыг хангахад тулгамдаж буй асуудлуудыг судалж дараах дүгнэлтэд хүрлээ.

Нэгдүгээрт. Төрийн улс төрийн алба болон төрийн тусгай албанд сүүлийн 5 жилийн байдлаар эмэгтэйчүүдийн эзлэх хувь 30 хувьд

ч хүрэхгүй байна. Тэнцүү тэгш гэх ойлголт 50:50-н харьцаатай байдаг. Гэхдээ хууль сахиулах байгууллагын чиг үүрэгтэй холбоотой эрэгтэйчүүдийн хүсэл, сонирхол чадварт суурилсан мэргэжил их байдаг ба эмэгтэйчүүдийн оролцоог их шаарддаггүй ч тэднийг онцлогт тохирсон чухал оролцоотой ажлууд олон бий. Тиймээс төрийн тусгай албанд эмэгтэйчүүдийн эзлэх хувийг 30%-40% байхаар холбогдох хуульд хуульчлах шаардлагатай байна. Ингэснээр яг тэнцүү болохгүй ч гэлээ эмэгтэйчүүдийн эзлэх хувь нэмэгдэхийн хэрээр чанаржиж тэдгээрийн төрийн тусгай албан эзлэх байр суурь, үүрэг оролцоо өснө.

Хоёрдугаарт. Хууль сахиулах байгууллагуудын ажилчин, алба хаагчдын жендерийн талаарх ойлголтыг нэмэгдүүлэх сургалт зохион байгуулах алба хаагчдын дунд жендерийг хүйсийн тэнцвэрт байдалтай ижил ойлгодог хэвшмэл ойлголт тогтмол хэвээр байна.

Гуравдугаарт. Монгол улсад хууль сахиулах ажиллагаанд хүний эрх, жендерийн тэгш байдлыг дээшлүүлэх нь төсөл, Эмэгтэйчүүдийн манлайллын хөтөлбөртэй холбоотой улс даяар зохион байгуулагдаж байгаа төсөл, судалгааны мэдээллийг түгээж олон эрэгтэй, эмэгтэй алба хаагчдыг оролцуулах. Эдгээр хөтөлбөрүүдийн талаар дийлэнх алба хаагчид ойлголттой байгаа боловч огт жендерийн тэгш байдлыг хангахтай холбоотой арга хэмжээнд оролцож

байгаагүй төрийн тусгай алба хаагч байсаар байна.

Дөрөвдүгээрт. Хууль сахиулах салбар дахь жендерийн тэгш байдлыг дээшлүүлэхийн тулд боловсрол, эдийн засаг, эрүүл мэнд, нийгэм соёлын хүрээнд арга хэмжээг авч байх. Ялангуяа эдийн засгийн хүрээнд алба хаагчдын цалин хөлсөнд анхаарах. Дээрх судалгаанаас эдгээр асуудлуудыг Хууль сахиулах салбарт жендерийн эрх тэгш байдлыг хангахад тулгамдаж буй асуудлууд мөн гэж тодорхойлж байгаа ч жендерийн тэгш байдлыг хангах бодлогыг судалж нийгэм өөрчлөгдөхийн хэрээр өөрчлөгдөх шаардлагуудыг бий болгосоор судалсаар л байна. Учир нь нийгэм, соёл өөрчлөгдөхийн хэрээр эрэгтэй эмэгтэй хүмүүсийн мэргэжил, сонирхол өөрчлөгдсөөр байх учир жендерийн тэгш байдал ч мөн хувьсан өөрчлөгдөнө.

Санал

Төрийн тусгай албанд Эмэгтэйчүүдийн эзлэх хувийг 30%-40% байхаар холбогдох хуульд хуульчлах шаардлагатай байна.

Хууль сахиулах байгууллагуудын ажилчин, алба хаагчдын жендерийн талаарх ойлголтыг нэмэгдүүлэх сургалт зохион байгуулах

Хууль сахиулах байгууллагын удирдлагууд нь хууль сахиулах салбарт ажиллаж буй алба хаагчдын жендерийн тэгш байдлыг хангахад нөлөөлж буй хүчин зүйлсийг судалж тодорхойлон Жендерийн үндэсний хороо болон Хүний эрхийн үндэсний

комисстой хамтарч ажиллаж тэр мэдээллээ ил тод нээлттэй байлгах.

АШИГЛАСАН ЭХ СУРВАЛЖ

1. Жендерийн эрх тэгш байдлыг хангах тухай хууль 2011 он

2. Төрийн албаны тухай хууль 2017 он

3. Хүний эрхийн үндэсний комисс 22 дах илтгэл

4. А.Гантуул. Шийдвэр гаргах түвшин дэх жендерийн тэгш байдлыг хангах зарим асуудал, Хууль

сахиулахуйн удирдлага сэтгүүл No 03, 2021 он

5. Төрийн албан хаагчийн улсын нэгдсэн тоо бүртгэлийн 2023 тайлан

6. Монгол улсын жендерийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээ 2022 он

7. <https://vip76.mn/content/40935>

8. <https://medium.com/@awaremongolia/>